



Монголбанк

# ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ

2018 ОНЫ 03 ДУГААР САР



**Макро эдийн засгийн  
тогтвортой орчинг  
бүрдүүлэх**



**Мөнгөний бодлогын  
хүүний шилжих  
нөлөөг сайжруулах**



**Банкуудын эрсдэл  
удирдах чадвар, үр  
ашиг, засаглалыг  
сайжруулах**

Зээлийн хүүг бууруулах стратегийн баримт бичиг боловсруулах ажлын хэсэг

## 01 Зээлийн хүүг бууруулах стратегийн тойм

Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгцээ шаардлага, алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилтууд.



## 02 Хадгаламж, зээлийн хүүнд нөлөөлж буй хүчин зүйлс

Хүү буурах макро эдийн засгийн тогтвортой орчинг бүрдүүлэх, бодлогын хүүний хадгаламж, зээлийн хүүнд үзүүлэх нөлөөг сайжруулах



## 03 Зээлийн хүү бууруулах стратегийн зорилтууд

Зээлийн хүүг бууруулахтай холбогдуулж 11 чиглэл бүхий стратегийн зорилтыг дэвшүүлж байна.



## 04 Стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.



- Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 7 дугаар тогтоолын 3 дах хэсэгт “Зээлийн хүү бууруулах стратеги боловсруулах” үүргийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан.
- Монголбанкны Ерөнхийлөгчийн А-241 дугаар тушаалаар “Зээлийн хүүг бууруулах стратегийн баримт бичгийн төсөл” боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан.
- Энэ стратеги нь манай оронд хийгдсэн судалгаанууд, уг стратегийн төслийн боловсруулах ажлын хэсгийн судалгааны үр дүнгийн тайланд суурилан боловсруулагдсан. Үүний зэрэгцээ тодорхой хугацаа заасан үйл ажиллагааны төлөвлөгөө, туршлагад суурилсан арга хэмжээнүүдийг багтаасан болно.

## Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Д/д	Нэр	Байгууллага	Ажлын хэсэг
1	Д.Ган-Очир	Монголбанкны Судалгаа, статистикийн газрын захирал	Ахлагч
3	Б.Ганбат	Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал	Гишүүн
4	Н.Батсайхан	Монголбанкны Хяналт, шалгалтын газрын захирал	Гишүүн
5	Б.Баярдаваа	Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал	Гишүүн
7	Р.Амаржаргал	Санхүү эдийн засгийн их сургуулийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга	Гишүүн
8	С.Дэмбэрэл	Эдийн засгийн тинк танк клубын үүсгэн байгуулагч	Гишүүн
9	Ж.Үнэнбат	Монголын банкны холбооны гүйцэтгэх захирал	Гишүүн
10	Л.Гантөмөр	Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал	Гишүүн
11	А.Энхбаяр	Голомт банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал	Гишүүн
12	Г.Бумчимэг	MEARC-ийн гүйцэтгэх захирал	Гишүүн
13	Г.Энхтүвшин	New Frontier LLC-ийн гүйцэтгэх захирал	Гишүүн
14	А.Ариунболд	МХЭХННХ-ийн удирдах зөвлөлийн гишүүн	Гишүүн
15	М.Халиунбат	МХЭХННХ-ийн удирдах зөвлөлийн гишүүн	Гишүүн

### 1.1. Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгцээ шаардлага

- Зээлийн хүү 2000 оноос 2012 оны хооронд тогтвортой буурсан;
- Сүүлийн 6 жилд өсөх хандлагатай буюу дунджаар **жилийн 20 орчим хувьтай** байна;
- Дундаас доогуур орлоготой орнуудын дундажтай харьцуулахад **5 нэгж хувиар**,
- Зүүн ази, Номхон Далайн орнуудын дундажтай харьцуулахад **10 гаруй нэгж хувиар** өндөр байна.

### 1.2. Алсын хараа

- “Зээлийн хүүг бууруулах стратеги” нь бизнес эрхлэх **санхүүгийн таатай орчинг бүрдүүлэх**, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгох алсын зорилготой.

### 1.3. Эрхэм зорилго

- Энэхүү стратегийн эрхэм зорилго нь зээлийн хүү буурах **макро эдийн засгийн орчинг** бүрдүүлэх, **бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх** (бодлогын хүүний шилжих сувгийг хүчтэй болгох), **банкуудын эрсдэл даах чадвар**, үр ашиг болон засаглалыг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авах замаар зээлийн хүүг бууруулахад оршино.



СТРАТЕГИ



ЗОРИЛГО



ЗОРИЛТУУД

**Зээлийн хүүг  
бууруулах  
стратеги**

**Макро эдийн засгийн  
тогтвортой орчин**

Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах

Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, улсын секторын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах.

Төсвийн сахилга батыг хангах, макро бодлогын уялдааг сайжруулах.

Эдийн засгийг төрөлжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх.

**Мөнгөний бодлогын  
хүүний шилжих  
нөлөө**

Бодлогын хүүний коридорыг ашиглан хүүний нөлөөг сайжруулах.

Санхүүгийн долларжилтыг бууруулах.

Хүчтэй санхүүгийн системтэй болох, ХЗЗ-ийн хөгжлийг эрчимжүүлэх.

**Банкуудын үр ашигт  
удирдлага**

Зээлийн мэдээллийн сан, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх.

Зээлийн эрсдэлийг бууруулах, энэ чиглэлд эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох

Банкуудын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх.


Төрийн болон санхүүгийн байгууллагуудын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах.

- Зээлийн хүү нь депозитын хүү, хүүний зөрүүний нийлбэрээр тодорхойлогдоно:  $r_L = r_D + sp$
- Хүүний зөрүү нь НББ-ийн задаргаагаар дээрх хэлбэрт бичигдэнэ.

$$sp = \frac{1}{2} \left( \frac{\alpha_D}{\beta_D} + \frac{\alpha_L}{\beta_L} \right) + \frac{1}{2} \left( \frac{C(L)}{L} + \frac{C(D)}{D} \right) - \frac{1}{4} \frac{U''(\bar{W})}{U'(\bar{W})} [(L + 2L_0)\sigma_L^2 + (L + D)\sigma_M^2 + 2(M_0 - L)\sigma_{LM}]$$

$$sp = -\delta r_L + \frac{OC}{D} + \frac{Prov}{D} + ROA * \frac{A}{D} - \frac{NII}{D} - \frac{NOII}{D}$$

Зээлийн хүүний задаргаа:



Депозитын хүү өндөр байгаа нь зээлийн хүү өндөр байх суурь нөхцөл болж байна.

- 14.0% = 10% ( $r_D$ ) + 3.9% ( $sp$ )
- 3.9% = 4.9% (OC) + 3.5% (LLP) + 1.1% (P) - 4.0% (NII+NOII) - 1.6%

## Марков-шилжилтийн загварын үр дүн

- Дэглэмээс хамаарч нөлөө нь өөрчлөгддөг хүчин зүйлс

Зээлийн хүү:  $IBR_{t-3}$ ,  $NPL_{t-5}$ ,  $IBRSD_t$ ,  $IBRSD_{t-3} \times NPL_{t-3}$ ,  $INF_{t-2}$ ,  $G\_M2_{t-6}$

Хүүний зөрүү:  $IBR_{t-4}$ ,  $NPL_{t-5}$ ,  $IBRSD_t$ ,  $INF_{t-2}$

Хадгаламжийн хүү:  $IBR_{t-1}$ ,  $G\_M2_{t-6}$ ,  $IP\_MA\_GAP_{t-3}$

- Аль дэглэмд байхаас үл хамааран нөлөөлөгчид

Зээлийн хүү:  $HNI\_D_t$ ,  $HNI\_L_t$ ,  $IP\_GAP_t$ ,  $G\_SM_{t-1}$ ,  $G\_FC_{t-1}$

Хүүний зөрүү:  $CR5\_D_t$ ,  $CR2\_L_t$ ,  $IP\_GAP_t$ ,  $G\_SM_{t-1}$

Хадгаламжийн хүү:  $HNI\_D_t$ ,  $G\_SM_{t-3}$

Зээлийн хүү ( $r_{L,t}$ )	
Түүвэр: 2002M12-2016M10	
Хувьсагчид	Коэфф
Дэглэм 1	
Тогтмол	29.2***
$IBR_{t-4}$	0.01
$NPL_{t-5}$	0.44***
$IBRSD_t$	0.34***
$IBRSD_{t-3} \times NPL_{t-3}$	0.06****
$INF_{t-2}$	-0.10
$G\_M2_{t-6}$	-0.02***

Дэглэм 2	
Тогтмол	21.2***
$IBR_{t-4}$	0.23***
$NPL_{t-5}$	0.86***
$IBRSD_t$	0.04
$IBRSD_{t-3} \times NPL_{t-3}$	0.03*
$INF_{t-2}$	0.45***
$G\_M2_{t-6}$	0.05***

Ерөнхий	
$HNI\_D_t$	-0.01***
$HNI\_L_t$	0.006**
$IP\_GAP_t$	-0.03***
$G\_SM_{t-1}$	-0.007***
$G\_FC_{t-1}$	0.004***
$\log(\sigma_t^2)$	-0.20***

Шилжилтийн матриц параметр	
$p_{11}$ : Тогтмол	4.31***
$p_{11}$ : $G\_L_{t-3}$	-0.48**
$p_{21}$ : Тогтмол	-2.15***
$p_{21}$ : $G\_L_{t-3}$	0.13
Log-likelihood	-233.3

Хүүний зөрүү ( $sp_t$ )	
Түүвэр: 2008M12-2016M10	
Хувьсагч	Коэфф
Дэглэм 1	
Сул гишүүн	5.94***
$IBR_{t-4}$	0.05
$NPL_{t-5}$	0.34***
$IBRSD_t$	1.18***
$INF_{t-2}$	0.27***

Дэглэм 2	
Сул гишүүн	3.64*
$IBR_{t-4}$	0.22***
$NPL_{t-5}$	0.39***
$IBRSD_t$	-0.09
$INF_{t-2}$	-0.02

Ерөнхий	
$CR5\_D_t$	-0.15***
$CR2\_L_t$	0.20***
$IP\_GAP_t$	-0.01***
$G\_SM_{t-1}$	-0.02***
$\log(\sigma_t^2)$	-0.70***

Шилжилтийн матриц параметр	
$p_{11}$ : Тогтмол	5.17***
$p_{21}$ : Тогтмол	-6.83**
Log-likelihood	-92.0

Хадгаламжийн хүү ( $r_{D,t}$ )	
Түүвэр: 2008M12-2016M10	
Хувьсагч	Коэфф
Дэглэм 1	
Сул гишүүн	13.8***
$IBR_{t-1}$	0.05*
$G\_M2_{t-6}$	-0.02***
$IP\_MA\_GAP_{t-3}$	-0.07***

Дэглэм 2	
Сул гишүүн	14.7***
$IBR_{t-1}$	0.07***
$G\_M2_{t-6}$	-0.02***
$IP\_MA\_GAP_{t-3}$	0.002

Ерөнхий	
$HNI\_D_t$	-0.001***
$G\_SM_{t-3}$	-0.001*
$\log(\sigma_t^2)$	-1.64***

Шилжилтийн матриц параметр	
$p_{11}$ : Тогтмол	3.25***
$p_{21}$ : Тогтмол	-4.38***
Log-likelihood	12.62

### Банкуудын эх үүсвэрийн зардал өндөр байхад:

- 1 өндөр, тогтворгүй инфляци, түүнийг дагасан бодлогын хүүний өндөр түвшин,
- 2 банкуудын эх үүсвэрийн төлөөх өрсөлдөөн,
- 3 санхүүгийн салбар дахь долларжилт, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралт,
- 4 дотоод эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийн тогтвортой бус байдал,
- 5 макро эдийн засгийн мөчлөг богино,
- 6 хөрөнгийн зах зээлийн хөгжил сул (үнэт цаас, бондын зах зээл нь хадгаламжийн бүтээгдэхүүнийг орлох сонголт болох хэмжээнд хүрч хөгжөөгүй),
- 7 банкуудын үйл хөдлөл буюу балансын бүтэц.

(Ган-Очир 2009, 2016).



Стратегийн тойм



Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс



Стратегийн зорилтууд



Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө

### Зээл, хадгаламжийн хүүний зөрүү өндөр байхад:

- 1 макро эдийн засгийн эрсдэл,
- 2 банк хоорондын захын хүү, түүний хэлбэлзэл,
- 3 зээлийн эрсдэл буюу чанаргүй зээл,
- 4 валютын ханшийн эрсдэл,
- 5 зээл, хадгаламжийн зах зээл дэх төвлөрөл,
- 6 санхүүгийн зах зээлийн ерөнхий хөгжил,
- 7 заавал байлгах нөөцийн хувь,
- 8 өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур,
- 9 банкуудын үйл ажиллагааны зардал,
- 10 банкуудын хүүгийн бус цэвэр зардал,
- 11 орлого авчирдаг активын нийт активд эзлэх хувь,
- 12 банкны удирдлагын ур чадвар,
- 13 банкны өргөжилтийн үр өгөөж (economy of scale).

(Ган-Очир 2006, 2009, 2016).



Зээлийн хүүнд нөлөөлөгч макро, микро хүчин зүйлс нь яагаад зээлийн хүүг өндөр түвшинд хадгалагдахад нөлөөлж буй суурь хүчин зүйлс нь (Ган-Очир 2006, 2009, 2016; Голомт банк 2017; Gan-Ochir and Kalirajan 2016; Баярдаваа болон бусад 2015):

- Монголын эдийн засаг гадаад шоконд хэт өртөмтгий;
- Нийлүүлэлтийн хүчин зүйлсээс хамаарч инфляци нь тогтворгүй, өндөр байж ирсэн;
- Макро эдийн засгийн бодлого нь сахилга батгүй, мөчлөг дагаж хэрэгжсэн;
- Гадаад валютын нөөц багатай, улсын секторын өр өндөр түвшинд хүрсэн;
- Санхүүгийн тогтвортой байдал хэврэг явсаар өнөөг хүрсэн;
- Санхүүгийн зах зээл дээрх төв банкны оролцоо хэт өндөр явж ирсэн;
- Банкуудын үйл хөдлөл мөчлөг дагасан шинжтэй байж ирсэн;
- Дотоод хуримтлал багатайгаас депозитын зах зээл дээрх эх үүсвэрийн төлөөх өрсөлдөөн хүчтэй;
- Санхүүгийн бизнес хийх ерөнхий эрсдэл өндөр;
- Институц, засаглалын чанар сул хэвээр байгаа зэрэг болно.



Зээлийн хүү буурах **макро эдийн засгийн тогтвортой орчинг бүрдүүлэх** хүрээнд:

1

- (1) Инфляцийг тогтвортой нам түвшинд байлгах,
- (2) Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, улсын секторын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах,
- (3) Төсвийн сахилга батыг хангах, мөчлөг сөрсөн макро бодлого хэрэгжүүлэх,
- (4) Эдийн засгийг төрөлжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх.

Мөнгөний **бодлогын хүүний банкуудын хадгаламж, зээлийн хүүнд шилжих нөлөөг** сайжруулах хүрээнд:

2

- (5) Бодлогын хүүний коридорын механизмыг ашиглан бодлогын хүүний нөлөөг сайжруулах,
- (6) Санхүүгийн долларжилтыг бууруулах,
- (7) Хүчтэй банкны салбартай болох, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх.

Банкуудын **эрсдэл удирдах чадвар, үр ашиг болон засаглалыг сайжруулах** хүрээнд:

3

- (8) Зээлийн мэдээллийн сан, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх,
- (9) Зээлийн эрсдэлийг бууруулах, энэ чиглэлд эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох,
- (10) Банкуудын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх,
- (11) Төрийн болон санхүүгийн байгууллагуудын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах.



## Стратеги

Монголбанкнаас зарласан инфляцийн зорилтот түвшинг жил дараалан тогтвортой хангах.

Эдийн засагт инфляци тэр орчим л байдаг гэсэн “инфляцийн зангуу”-г бий болгох.

Инфляцийг тогтвортой нам түвшинд байлгахад чиглэсэн макро эдийн засгийн болон бүтцийн бодлогын арга хэмжээг авах.

Манлайлж хариуцах байгууллага

Монголбанк, Засгийн газар

Бусад оролцох байгууллагууд

Сангийн яам, ХХААХҮЯ, УУХҮЯ, ЗТХЯ



Стратегийн тойм



Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс



Стратегийн зорилтууд



Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө

## Үндэслэл, шаардлага

- Инфляци, түүний хүлээлт нь хадгаламж, зээлийн хүүг тодорхойлогч гол хүчин зүйл;
- Инфляци хэлбэлзэл өндөртэй байх нь банкны хүүний шийдвэрт нөлөөлнө;
- Инфляци өндөр байх нь бодлогын хүү өндөр тогтох нөхцөл;
- Бүтээгдэхүүний өртөг, үнэ өндөр байхад логистик, дэд бүтцийн сул хөгжил нөлөөлнө;
- Валютын ханшийн огцом хэлбэлзэл, эдийн засгийн хэлбэлзлийг бий болгохгүй байх;

## Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Инфляцийг тогтвортой, зорилтот түвшинд хадгалах;
- Төсвийн бодлого нь инфляцийн зорилтот харшлахгүй байхаар боловсруулагдаж, хэрэгжих;
- Төв банкны үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг бүрэн хангах;
- Төв банкнаас төсвийн шинж чанартай үйл ажиллагаанд оролцохгүй байх;
- Үнийн тогтвортой байдал, бодлогын хүү, валютын ханшийн “зохицуулалттай хөвөгч” дэглэм гэсэн тогтолцоог бүрэн нутагшуулах;
- Зах зээлд оролцогчдын төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх;
- Хөрөнгийн дотогшлох, гадагшлах урсгал огцом нэмэгдэх үед авч хэрэгжүүлэх макро эдийн засгийн удирдлагыг тодорхой болгох (макро зохистой бодлого);
- Засгийн газрын зүгээс нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийг бага байлгахад чиглэсэн бүтцийн бодлого хэрэгжүүлэх;
- Суурь инфляцийг олон улсад нийтлэг ашиглагддаг аргачлалуудаар тооцох, шийдвэр гаргалтад ашиглах.



## Стратеги

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзэл үүсгэхгүйгээр гадаад валютын цэвэр нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай арга хэмжээ (цэвэр экспорт, хувийн хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх).

Улсын секторын гадаад өрийг арилжааны нөхцөлтэй зээлээр нэмэгдүүлэхгүй байх.

Монгол улсын зээлжих зэрэглэл нэмэгдүүлэх, гадаад зах зээлээс хямд эх үүсвэр бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах.

**Манлайлж хариуцах байгууллага**

Засгийн газар, Монголбанк

**Бусад оролцох байгууллагууд**

Сангийн яам, УУХҮЯ



Стратегийн тойм



Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс



Стратегийн зорилтууд



Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө

## Үндэслэл, шаардлага

- Гадаад валютын нөөцөөс эдийн засгийн аюулгүй байдал, дархлаа хамаарна.
  - Эдийн засагт буффер бий болгох
- Гадаад валютын нөөцийн хэмжээ нь гадаад өр төлбөрийг төлж барагдуулах, эдийн засгийн дархлааг хангах түвшинд бус байна.
- Улсын секторын гадаад өр өндөр түвшинд хүрсэн.
- Зээлжих зэрэглэл муудаж, эрсдэлийн нэмэгдлийн үнэ өндөр байна.
- Ийм нөхцөлд:
  - Гадаад эх үүсвэрийн хүү өндөр
  - Төсөв, мөнгөний бодлогоор эдийн засгийг идэвхжүүлэх, бодлогын хүүг бууруулах боломж хязгаарлагдмал.

## Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Улсын секторын өндөр хүүтэй гадаад өрийг бууруулах, хөнгөлөлттэй нөхцөлтэй өрөөр солих.
- Гадаад валютын нөөцийн хуримтлал, улсын секторын гадаад өрийн төлөлтийг уялдуулах.
- Эдийн засаг, улс төрийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, экспортын саад тотгорыг арилгах.
- Экспортод гарах үйлдвэрлэгчдийг дэмжих төрийн бодлогыг тодорхой болгож, хэрэгжүүлэх.
- Уул уурхайн томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах.
- Экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, өртгийг бууруулах дэд бүтцийг барьж байгуулах.
- Өрсөлдөх давуу талтай импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх.
- Экспортлогч үйлдвэрлэгчдийг илүү томорч үндэсний том компани болоход дэмжлэг үзүүлэх.



## Стратеги

Төсвийн алдагдлыг шат дараатай бууруулж, ашигтай гаргах замаар засгийн газрын өрийг бууруулах

- Төсвийн бодлогыг улс төрийн амлалт, ашиг сонирхлоос ангид байлгах, төсвийн сахилга батыг хангах
- Төсвийн зөвлөл дээр төсвийн бодлогын бусад бодлогуудтай хэрхэн уялдаж байгаа талаарх дүгнэлт, зөвлөмж гаргах

- “Улс төрийн мөчлөг”, эдийн засгийн хэлбэлзэл буурах
- Төсвийн болон өрийн тогтвортой байдал хангагдах
- Зээлжих зэрэглэл нэмэгдэх
- Гадаад зах зээлээс хямд эх үүсвэр, хөрөнгө оруулалт татах

Манлайлж хариуцах байгууллага

Засгийн газар, Сангийн яам, Хууль зүйн яам

Бусад оролцох байгууллагууд

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Бусад яамдууд



Стратегийн тойм



Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс



Стратегийн зорилтууд



Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө

## Үндэслэл, шаардлага

- Улсын төсвийн хэт тэлэлт, түүнийг дагасан төсвийн алдагдал нь өрийн өсөлтийг бий болгосон.
  - Өрийн тогтворгүй байдлын эрсдэл
  - Гадаад валютын нөөц буурах: “цэвэр экспортын шахан гаргалт”
  - Инфляци, ханшийн хэлбэлзэл-> Бодлогын хүү
  - Хувийн хөрөнгө оруулалтын “шахан гаргалт”: зээлийн нийлүүлэлт бага
  - Зээлжих зэрэглэл буурах: гадаад зах зээлээс эх үүсвэр бүрдүүлэх зардал өндөр
- Засгийн газрын зардлын тэлэлт: Концессын гэрээ
  - Концессын төлбөрөө хугацаанд нь төлдөггүй -> Чанаргүй зээл

## Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдааг нийгмийн сайн сайхан байдал хангагдах байдлаар сайжруулах.
- Төсвийн алдагдлыг жил тутамд аажим бууруулж, зохистой түвшинд хүргэх.
- Төсвийн урсгал зардлыг тэлэхгүй байх, халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх.
- Төсвийн алдагдлыг арилжааны нөхцөлтэй эх үүсвэрээр санхүүжүүлэхгүй байх.
- Төсвийн сахилга батыг дээшлүүлэх, баялгийн санг бүрдүүлэх.
- Уул уурхайн салбараас орж буй орлогын удирдлага, зохицуулалтыг боловсронгуй болгох.
- Төсвийн бодлого, төлөвлөлтийн механизмыг боловсронгуй болгох.
- Засгийн газрын концессын гэрээ байгуулах механизмыг төсөвтэй уялдуулах, концессын гэрээний үүргээ биелүүлэх.
- Бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг бэлтгэл сайтай, сайн төслийн менежментийн дор хэрэгжүүлдэг байх.





## Стратеги

Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх нэгдсэн бодлого гаргаж, шат дараатай хэрэгжүүлэх

Эдийн засгийн төрөлжилтийг экспортын төрөлжилтөд түшиглэх

Ажлын байрны өсөлтөөс гадна бүтээмжийн өсөлтөд онцгой анхаарах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг нэмэгдүүлж, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх

- Эдийн засгийн гадаад шоконд тэсч үлдэх дархлаа сайжирна.
- Чанартай ажлын байр нэмэгдэж, хөдөлмөр эрхлэлтийн орлого нэмэгдэнэ.
- Гадаад валютын орлого нэмэгдэж, үндэсний хуримтлал нэмэгдэнэ.

Манлайлж хариуцах байгууллага

Засгийн газар, Үндэсний хөгжлийн газар

Бусад оролцох байгууллагууд

Сангийн яам, Хөгжлийн банк, бусад яамдууд



Стратегийн тойм



Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс



Стратегийн зорилтууд



Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө

## Үндэслэл, шаардлага

- Манай эдийн засгийн бүтцэд төрөлжилт бий болохгүй тохиолдолд уул уурхайг дагасан гадаад шокууд нь эдийн засгийн хэлбэлзлийг бий болгосоор байх болно.
  - Эдийн засгийн тогтворгүй байдал,
  - Дотоод хуримтлал бий болгох боломжгүй,
  - Ажилгүйдэл, ядуурал өндөр байх,
  - Урсгал тэнцлийн алдагдал, гадаад өрийн өсөлт,
  - Зээлжих зэрэглэл муу байх,
  - Санхүүгийн зах зээл тогтвортой байх, хүү буурах боломжийг хязгаарласаар байна.
- Эдийн засгийн төрөлжилт -> экспортын төрөлжилт-> боловсруулах үйлдвэржилт-> бүтээмжид суурилсан чанартай ажлын байр-> орлогын өсөлт -> дотоод хуримтлал

## Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Эдийн засаг, экспортыг төрөлжүүлэх нэгдсэн бодлогыг боловсруулж, салбар бүр дээрх нарийвчилсан төлөвлөгөө гаргах.
  - Харилцан уялдаатай байх
  - Санхүүжилт нь маш тодорхой байх
- Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай зүтгүүр хэдэн компанийг бий болгож дэмжих.
- Экспортыг дэмжих төрийн агентлаг байгуулж, мэргэшсэн үйл ажиллагаа эрхлүүлэх.
- Бүтээмжийг нэмэгдүүлэх асуудлыг нэг институцэд хариуцуулах.
- Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих.
- Аялал жуулчлал, үйлчилгээний салбарыг хөгжлийг уялдуулах, дэд бүтцийг сайжруулах.



## Зээлийн хүүг бууруулах стратеги

### Макро эдийн засгийн тогтвортой орчин

Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах

Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, улсын секторын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах.

Төсвийн сахилга батыг хангах, макро бодлогын уялдааг сайжруулах.

Эдийн засгийг төрөлжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх.

### Мөнгөний бодлогын хүүний шилжих нөлөө

Бодлогын хүүний коридорыг ашиглан хүүний нөлөөг сайжруулах.

Санхүүгийн долларжилтыг бууруулах.

Хүчтэй санхүүгийн системтэй болох, ХЗЗ-ийн хөгжлийг эрчимжүүлэх.

### Банкуудын үр ашигт удирдлага

Зээлийн мэдээллийн сан, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх.

Зээлийн эрсдэлийг бууруулах, энэ чиглэлд эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох

Банкуудын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх.

Төрийн болон санхүүгийн байгууллагуудын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах.

## Стратеги

Бодлогын хүүний коридорын дээд, доод хязгаар дээрх төв банкнаас эх үүсвэр нийлүүлэх, эх үүсвэр татах байнгын хэрэгслийн хугацааг уртасгах, хүүг бодлогын хүүнд ойртуулах

- Депозитын зах зээл дээрх үр ашиггүй өрсөлдөөн буурах
- Мөнгөний бодлогын хүүний сувгийн нөлөөг сайжруулах
- Зээлийн зах зээл дээрх өрсөлдөөн нь хүүг бууруулахад чиглэнэ (нөхцөлөө сулруулах өрсөлдөөнөөс давхар сэргийлэх шаардлагатай)

Хадгаламжийн хүүг өсгөх өрсөлдөөн буурч, эх үүсвэрийн хүү буурсан үед л төв банкны хэрэгслийн хугацааг хугацааг бууруулж, банк хоорондын захын идэвхжилтийг сэргээнэ.

Манлайлж хариуцах байгууллага

Монголбанк

Бусад оролцох байгууллагууд

Монголын банкны холбоо, Арилжааны банкууд



Стратегийн тойм



Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс



Стратегийн зорилтууд



Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө

## Үндэслэл, шаардлага

- Банкуудын хугацаатай хадгаламжийн хүүний шийдвэрт төв банкны овернайт санхүүжилтийн хүү тусгалаа олохгүй байна.
  - Хэт богино хугацаатай тул тус эх үүсвэрийн хүү, хэмжээ нь банкны зээлийн шийдвэрт нөлөөлөхгүй байна.
  - Зөвхөн заавал байлгах нөөцийг хангахад л ашиглагдаж байна.
- Депозитын зах зээл дээрх үр ашиггүй өрсөлдөөн нь хүүний сувгийн нөлөө сул байх, хүү өндөр байхад нөлөөлж байна.
  - Жижиг банкууд харьцангуй өндөр амлана.
  - Том хадгаламж эзэмшигчид хэлцэлд илүү нөлөөтэй байна.
- Бодлогын хүү хаана тогтох нь зээлийн хүүг бууруулах зорилгоор бус инфляцийн зорилт, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тодорхойлогдоно.

## Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Төв банкнаас санхүүжилт олгох байнгын хэрэгслийн хугацаа овернайт байгааг уртасгах (1 сар хүртэл болгох)
- Хүүний коридорыг илүү нарийн буюу бодлогын хүү  $\pm 1$  нэгж хувь болгох
- Мөнгөний бодлогын болон санхүүгийн зах зээлийн шийдвэрт суурь инфляцийг харгалздаг жишиг тогтоох.
- Төв банк санхүүгийн зах зээлд зах зээлийн бус нөхцөлөөр шууд оролцож, зах зээлийг гажуудуулахгүй байх.
- Бодлогын хүүнээс доогуур хүүгээр банкуудад эх үүсвэр өгөхгүй байх.
- Хөвөгч хүүтэй хадгаламжийн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлэхийг дэмжих.



## Стратеги

Засгийн газар, арилжааны банкууд, өрх гэр болон аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн долларжилтыг бууруулах



Банкуудын зээлийн хувьд макро зохистой бодлогын хэрэгслүүдийг долларжилтыг бууруулах зорилгоор ашиглах

Засгийн газрын гадаад өрийн хувьд эдийн засаг дахь хүүний бууралттай уялдуулан дотоод өр рүү шилжих арга хэмжээг авах

Гадаад валютын своп, форвард зах зээлийг хөгжүүлэх



Банкуудын зээлийн эрсдэл буурна, эдийн засгийн тогтвортой байдал хангагдаж, хүүний сувгийн нөлөө сайжирна

Манлайлж хариуцах байгууллага

Монголбанк, Сангийн яам

Бусад оролцох байгууллагууд

Арилжааны банкууд



Стратегийн тойм



Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс



Стратегийн зорилтууд



Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө

## Үндэслэл, шаардлага

- Санхүүгийн долларжилт нь бодлогын хүүний банкуудын хүүнд үзүүлэх нөлөө сул байхад нөлөөлж байна.
  - Төгрөг болон гадаад валютын зээлийн хооронд шилжилт хийнэ.
  - Бодлогын хүүний гадаад валютын зээлийн хүүнд үзүүлэх нөлөө сул.
- Долларжсан эдийн засагт ханшийн хэлбэлзэл нь долларжилтыг улам нэмэгдүүлдэг.
  - Зээлийн 21%, депозитын 29%
  - Нийт гадаад өр 27.4 тэрбум \$, ЗГ & ТБ-ны гадаад өр 9.3 тэрбум \$
  - “Хөвөх айдас” бий болгодог
- Гадаад валютын зээл цаашид өсөн нэмэгдэхээс сэргийлэх
  - Ханшийн чангаралтын “эрсдэл авах суваг”
  - Макро зохистой бодлогын хэрэгслүүд
- Гадаад валютын хямд эх үүсвэрийг төгрөг рүү хөрвүүлэх урт хугацаат своп, форвард хэлцлийн зах зээлийг давхар хөгжүүлэх

## Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Санхүүгийн долларжилтыг бууруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.
- Төгрөгийн ЗБН-ийн хувийг валютын ЗБН-ийн хувиас багаар тогтоох.
- Шаардлагатай тохиолдолд зарим зээлүүд (өрхийн зээл, \$-ийн орлогогүй ААН гэх мэт) дээр валютын зээлийн эрсдэлийн жинг нэмэгдүүлэх.
- Засгийн газрын өрийн долларжилтыг бууруулах.
- Төгрөгөөс гадаад валютад шилжүүлэх гүйлгээнд шимтгэл ногдуулах.
- Дериватив (своп, форвард) зах зээлийг хөгжүүлэх.
- Валютын ханшийн уян хатан байдлыг “зохицуулалттай хөвөгч” ханшийн дэглэмийн хүрээнд хангах



## Стратеги

Санхүүгийн системийг хөгжүүлэх, олон тулгууртай болгох зорилгоор хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх

Үндэсний томоохон компаниудыг нээлттэй компани болгох, зэрэглэл тогтоогч байгууллагуудыг бий болгох

Хөрөнгийн зах зээлийн гол оролцогчид болсон институциональ хөрөнгө оруулагч нар бий болоход дэмжлэг үзүүлэх

Хөрөнгийн захын үйл ажиллагаа идэвхэжсэнээр мөнгөний бодлогын хүүний суваг сайжирч, банкуудын зээлийн зах зээл дээрх өрсөлдөөн нэмэгдэж, зээлийн хүү буурах

**Манлайлж хариуцах байгууллага**

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

**Бусад оролцох байгууллагууд**

Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөрөнгийн бирж, Монголын банкуудын холбоо.



Стратегийн тойм



Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс



Стратегийн зорилтууд



Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө



## Үндэслэл, шаардлага

- Санхүүгийн зах зээлийн хөгжил сул байснаар бодлогын хүүний шилжилтийг сулруулдаг.
  - Банкны зээлийн эрэлтийн хүүнээс хамаарах мэдрэмж сул;
  - Бодлогын хүүнд аль зах зээл хурдан хариу үйлдэл үзүүлнэ тус захын үйл ажиллагаа идэвхитэй байна;
  - Дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх (эс долларжилт бий болгоно)
- Банкны салбарын активын чанарын үнэлгээ хийгдсэн
  - Эрсдэл даах чадвартай, хүчтэй банкны салбарын суурь;
  - Мөнгөний бодлого болон макро зохистой бодлогын үр нөлөөг нэмэгдүүлнэ;
- Банкны салбарын төвлөрөл нь хүүний сувгийн нөлөөг сулруулдаг.
  - Хүүг өөрчлөх бус хүүний зөрүүг нэмэгдүүлдэг
  - Төвлөрлийг сааруулах, өрсөлдөөнийг урамшуулах
- Хөрөнгийн зах зээлийн нийлүүлэлт, эрэлтийн талын аль алиныг хөгжүүлэх

## Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- “Монгол улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах.
- Жишиг хүүг тогтоох, эрсдэлгүй активыг зах зээл дээр байлгах зорилгоор ЗГҮЦ-ыг дотоодын зах зээлд тогтмол гаргаж байх.
- Санхүүгийн захад эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвшүүлж, өрсөлдөөнийг дэмжих.
- Үнэт цаасны зах зээлд оролцогч компаниудад зохистой засаглалын зарчмыг мөрдүүлэх.
- Институциоаль хөрөнгө оруулагчид бий болгох асуудлыг бодлогоор дэмжих.
- Дотоодын бие даасан рейтинг тогтоогч байгууллагуудыг бий болгох.
- Банкны салбар дахь төвлөрлийг сааруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээ авах.
- Банкнаас бусад санхүүгийн байгууллагын статистик мэдээллийн статистик мэдээллийн чанарыг сайжруулж, хамрах хүрээг нэмэгдүүлэх.



### Макро эдийн засгийн тогтвортой орчин

Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах

Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, улсын секторын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах.

Төсвийн сахилга батыг хангах, макро бодлогын уялдааг сайжруулах.

Эдийн засгийг төрөлжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх.

### Мөнгөний бодлогын хүүний шилжих нөлөө

Бодлогын хүүний коридорыг ашиглан хүүний нөлөөг сайжруулах.

Санхүүгийн долларжилтыг бууруулах.

Хүчтэй санхүүгийн системтэй болох, ХЗЗ-ийн хөгжлийг эрчимжүүлэх.

### Банкуудын үр ашигт удирдлага

Зээлийн мэдээллийн сан, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх.

Зээлийн эрсдэлийг бууруулах, энэ чиглэлд эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох

Банкуудын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх.

Төрийн болон санхүүгийн байгууллагуудын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах.

Зээлийн хүүг бууруулах стратеги

## Стратеги

Зээлийн мэдээллийн санг өргөжүүлж (зээлийн эрсдэлийн өгөгдлийн сан), бие даасан нэгжид шилжүүлснээр зээлдэгчийн зээлийн эрсдэлийн үнэлгээг хийдэг институцтэй болох

Зээлийн батлан даалтын үйл ажиллагааг өргөжүүлснээр ЖДҮ-ийн зээлийн өсөлт эдийн засгийн болон санхүүгийн мөчлөгөөс үл хамааран тогтвортой байж, зээлийн хүү буурах

Зээлийн эрсдэл буурах, барьцаа хөрөнгийн шаардлага багасах, зээлийн хүртээмж нэмэгдэх, хүү буурах боломж бүрдэнэ.

**Манлайлж хариуцах байгууллага**

Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо

**Бусад оролцох байгууллагууд**

Зээлийн батлан даалтын сан



Стратегийн тойм



Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс



Стратегийн зорилтууд



Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө

## Үндэслэл, шаардлага

- Зээлийн мэдээллийн сангийн одоогийн бааз нь зээлдэгчийн эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай хангалттай мэдээллийг агуулахгүй
  - Зээлийн эрсдэлийн үнэлгээг сайжруулах: зээлийн эрсдэлийн том өгөгдлийн сан;
  - Зээлдэгч бүрийн эрсдэлийн үнэлгээ (credit risk scoring)- Асимметрик мэдээллийг бууруулах;
  - Сайн зээлдэгч -> бага барьцаа, хүү;
  - Зээл судлах үйл ажиллагааны зардал буурна;
- Зээлийн батлан даалт нь барьцаа хөрөнгийг орлох, эрсдэлийг “даатгах” хэлбэр
  - ЖДҮ-ийн зээлийг дэмжихэд өргөн хэрэглэдэг;
  - ЗБДСангийн мөнгөн хөрөнгийн хэмжээ бага, үйл ажиллагаа нь хязгаарлагдмал байна;
  - ЖДҮ-ийн зээл нь эдийн засгийн болон санхүүгийн мөчлөгөөс хамгийн түрүүнд хамаардаг;

## Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Зээлийн мэдээллийн санг өргөтгөх:
  - Бүх санхүүгийн байгууллагуудын мэдээллийг нэгтгэн оруулах.
  - Төрийн эрх бүхий байгууллагуудын мэдээллийн сантай мэдээлэл солилцох.
- Зээлдэгчийн зээлийн эрсдэлийн үнэлгээг хийх бие даасан нэгж, институцийг байгуулах.
- Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэн өргөжүүлэх, идэвхжүүлэх, санхүүгийн эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх.
- Зээлийн батлан даалтыг шимтгэл нь зээлдэгч бүрийн хувьд ялгаатай байх “шударга” тогтолцоонд шилжих.
- Эдийн засгийн өрнөлийн үед шимтгэл нь өсдөг, уналтын үед буурдаг байхаар бодлогын хэрэгсэл болгон ашиглах.



## Стратеги

Олон улсын шилдэг туршлагад суурилсан актив удирдлагын үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх

Муу зээлийг шийдвэрлэх, шүүхийн бус журмаар барьцаа хөрөнгийг шууд худалдан борлуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх

Банкны зардал, зээлийн эрсдэл буурч, зээлийн хүү буурах

**Манлайлж хариуцах байгууллага**

Монголбанк, Сангийн яам,

**Бусад оролцох байгууллагууд**

Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкуудын холбоо, арилжааны банкууд,



Стратегийн тойм



Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс



Стратегийн зорилтууд



Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө

## Үндэслэл шаардлага

- Хүүний зөрүүнд нөлөөлдөг гол хүчин зүйл нь зээлийн эрсдэл.
  - Банкуудын чанаргүй зээлийн хэмжээ 2018 оны 1 дүгээр сарын байдлаар 1.2 их наяд төгрөг буюу нийт зээлийн 8.8 хувьтай тэнцэж байна.
  - Чанаргүй зээл энэ өндөр түвшинд хадгалагдах тохиолдолд зээлийн хүү буурах боломжийг хязгаарлана.
  - Хэрэглээний зээл хурдацтай өсөн нэмэгдэж байна
- Банкуудын харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг илүү боловсронгуй болгох
  - Credit risk scoring
  - Зээлийн хугацаа, хүү, ашиглалт уялдуулах
- Эрх зүй болон институцийн орчин сул байх нь гэрээний үүргийн хэрэгжилтийн хангуулахад хүндрэл учруулдаг
  - Олон шатны шүүх хурал (ҮА-ны зардал)
  - Шүүхийн шийдвэр нь зээлдэгч гэрээний үүргээ биелүүлэхгүй байхад туслах эрсдэл

## Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Олон улсын шилдэг туршлагад суурилсан актив удирдлагын үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх
- Хэрэглээний зээлийн хугацаа болон өр, орлогын харьцааг оновчтой тогтоон банкуудаар мөрдүүлэх.
- Зээлийн даатгал, баталгаа, батлан даалт, актив удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох.
- Санхүүгийн байгууллагын зээлийн барьцаа хөрөнгөтэй холбоотой хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох.
- Банкны зээлийн барьцаа хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулах.
- Зээлийн барьцаа хөрөнгийн нэгдсэн мэдээллийн санг эд хөрөнгийн бүртгэлийн системтэй холбох
- Санхүүгийн байгууллагуудын өр барагдуулах тогтолцоог боловсронгуй болгох.



## Стратеги

Банкуудын үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлж байгаа, гэхдээ хамтын ажиллагааг сайжруулах, FinTech-ийн хөгжлийг ашиглах замаар шийдвэрлэх боломжтой зардлуудыг бууруулна.

Банкуудын зардал буурч, хүүний зөрүү буурахад эерэгээр нөлөөлнө.

**Манлайлж хариуцах байгууллага**

Монголбанк, Сангийн яам,

**Бусад оролцох байгууллагууд**

Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкуудын холбоо, арилжааны банкууд



Стратегийн тойм



Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс



Стратегийн зорилтууд



Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө

## Үндэслэл, шаардлага

- Банкууд технологийн дэвшлийг ашиглаж эхэлсэн нь цаашид үйл ажиллагааны зардал буурах нөхцөлийг бүрдүүлж байна.
- Гэхдээ дэлгүүр болгоны касс дээрх банк тус бүрийн ПОС-ын машин болон зэрэгцээ орших банкуудын АТМ нь манай эдийн засгийн хувьд үр ашиггүй зардлын жишээ юм.
  - Шимтгэлийн орлого, мөнгөн урсгалын төлөөх өрсөлдөөн;
  - Банкуудын харилцан тохиролцоо, технологийн шийдлээр шийдвэрлэх боломжтой;
  - Нэг газар зэрэгцэх бус, тархалтыг сайжруулах;
- FinTech-ийн хурдацтай хөгжил нь харилцагчид хүссэн үйлчилгээг бага зардлаар хүргэх боломжийг олгож байна.
  - Салбарын тоо, үйл ажиллагааны зардлыг бууруулна
  - Харилцагчийн онцлогт тохирсон үйлчилгээний аргыг сонгох

## Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Биллер (i.e., ПОС)-ийн нэгдсэн системтэй болж, олон улсын жишигт нийцүүлэх.
- АТМ-ын цэнэглэлт, засвар үйлчилгээг төвлөрсөн байдлаар шийдэх, шийдэл, боломжийг олж хэрэгжүүлэх.
- FinTech-ийн дэвшлийг санхүүгийн салбарын үйлчилгээнд ашиглах ажлыг эрчимжүүлэх.
  - FinTech инновацийн төв байгуулах эсэх асуудлаар шийдэлд хүрэх
- Свифтийн нэгдсэн гарцыг бий болгох боломжийг судлах.
- Банкууд санхүүгийн үндсэн үйл ажиллагаатай холбоогүй үйл ажиллагаа эрхлэх, өндөр зардал гаргах асуудалд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авах.
- Цахим банкны үйлчилгээг ашиглан даатгалын гэрээг цахимаар байгуулах боломжийг судалж, холбогдох арга хэмжээг авах.





## Стратеги

Монгол улсын засаглал, институцийг сайжруулах цогц стратегитай болох  
Санхүүгийн байгууллагуудын засаглалыг олон улсын жишигт хүргэн сайжруулах

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хяналт шалгалтыг сайжруулж, эрх зүйн орчныг тодорхой болгох

- Эдийн засгийн бодлого, арга хэмжээнүүд дэх улс төрийн нөлөөг хязгаарлана.
- Санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ мөчлөг дагасан банкны үйл хөдлөл буурна.
- Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин боловсронгуй болно.

**Манлайлж хариуцах байгууллага**

Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо,

**Бусад оролцох байгууллагууд**

Сангийн яам, ХЗДХЯ, Монголын банкуудын холбоо



Стратегийн тойм



Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс



Стратегийн зорилтууд



Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө

## Үндэслэл шаардлага

- Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтээр сүүлийн 20 жилд авилгалын хяналт, засгийн газрын үр дүнтэй байдал, улс төрийн тогтвортой байдал, төрийн зохицуулалтын чанар, хууль ёс хэрэгжих байдал, хариуцлага хүлээх байдал гэсэн үзүүлэлтүүдэд ахиц дэвшил гараагүй, харин ч дордсон.
  - Институци төлөвшөөгүй, засаглал сул
  - Эдийн засаг дахь улс төрийн нөлөө хүчтэй болсон
- Институци, засаглалын чанарыг сайжруулах
  - Зээлийн хүүг бууруулах бодлого, стратегийн хэрэгжилт нь төрийн макро болон бүтцийн олон бодлогын реформ шаардана.
- Банкны салбар дахь principle-agent асуудал
  - Банкны мөчлөг дагасан үйл хөдлөл
  - Зээлийн өндөр өсөлт-> чанаргүй зээл-> зардал -> өөрийн хөрөнгийн дутагдал
  - Компанийн засаглал сайжруулах-> нэг эзний ДС-нд эзлэх дээд хувийг хязгаарлах/нээлттэй компани болгох

## Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- ‘Монгол улсын засаглал, институцийг сайжруулах үндэсний стратеги’ боловсруулан хэрэгжүүлэх.
- Банкны нэг өмчлөгчид тавих дүрмийн сангийн дээд хэмжээг хязгаарлах.
- Санхүүгийн байгууллагуудад зохистой засаглалын зарчмууд, шилдэг туршлагауудыг мөрдүүлэх.
- Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.
  - “Санхүүгийн хэрэглэгч” болон “Мөнгө хүүлэлт” гэсэн нэр томъёог холбогдох хууль тогтоомжид оруулах
- Банкны зээлийн журам, түүний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих.
- Хадгаламжийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, даатгалын хамрах хүрээг өргөтгөх.
- Санхүүгийн байгууллагууд, тэдгээрийн харилцагчид болон олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх.
- Санхүүгийн хэрэглэгчийн эрх, зээлээ хугацаанаас нь өмнө төлөх боломжийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох.



- Арга хэмжээний төлөвлөгөөг богино болон дунд хугацаанд ангилан стратегийн зорилт тус бүрийн хувьд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, манлайлан хэрэгжүүлэгч байгууллагыг харуулах байдлаар боловсруулсан.
- Зээлийн хүүг бууруулах стратегийг хэрэгжүүлэхэд энэхүү арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох байгууллага тус бүрийн хариуцан хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө болгон зохион байгуулах ёстой болно.
- Төрийн болон хувийн хэвшлийн бүх оролцогч талуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо нь энэ стратегийг амжилттай хэрэгжүүлэх, зээлийн хүүг бууруулахад туйлын чухал юм.



Стратегийн тойм

Зээлийн хүүнд нөлөөлж  
буй хүчин зүйлс

Стратегийн зорилтууд

Хэрэгжүүлэх арга  
хэмжээний төлөвлөгөө



Монголбанк

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА**